



Н.ГАНТУЛГА
Хууль сахиулах
их сургуулийн
Шүүхийн шийдвэр
гүйцэтгэлийн
сургуулийн захирал,
хууль зүй доктор, дэд
профессор, хурандаа



Н.БАТДОРЖ
Хууль сахиулахын их
сургуулийн Ахлагчийн
сургуулийн ахлах
багш, хошууч

ХОРИХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ШИНЭТГЭЛИЙН ЗАРИМ АСУУДАЛ

*“Энэ ертөнцөд бүхий л цаг
хугацаанд нийцсэн тогс шийдвэр
байх боломжгүй бөгөөд хамгийн
зов, найдвартай дүгнэлт-шийдлийг
гагцхүү мэтгэлцэн, харилцан
ойлголцол, зовшилцлоос олж болно”*

Хураангуй

Энэ илтгэлд шинээр боловсруулж
буй Хорих ял эдлүүлэх хуулийн төсөлд
тусгах боломжтой онол, эрх зүй,
практикийн ач холбогдолтой судлаачийн
зарим дүгнэлт, саналыг илэрхийлсэн
болно.

Түлхүүр үг

Хуулийн үзэл баримтлал, хорих ял
эдлүүлэх эрх зүйн зарчим, хоригдол,
хоригдлын эргэлт уулзалт, захидал
харилцаа, тодорхой бүлгийн эрх, онцгой

нөхцөлийн дэглэм, хоригдолд чөлөө
олгох асуудал, аюулгүй байдал зэрэг.

Монгол улсын эрх зүйн тогтолцоонд
Хорих ял эдлүүлэх эрх зүй нь эрх зүйн
олон салбарын хууль тогтоомжтой
холбогдон зорилго, зорилтуудаа
хангадаг болон нарийвчилсан,
тусгайлсан зохицуулалтаараа ялгардаг.

Мөн энэ харилцааны явцад үндэсний
төдийгүй, олон улсын эрх зүйн нийтлэг
эх сурвалжид бататгагдан тунхаглагдсан
хүний /иргэний/ үндсэн зарим эрхүүд¹
хязгаарлагддаг.

Манай улсад шинэ цагийн эрх зүйн
тогтолцоо бий болж 90 гаруй жил
хөгжих хугацаанд хорих ял эдлүүлэх
төрөлжсөн хуулиуд /1931, 1966, 1981,
1993, 1996, 2002 онуудад/, тэдгээрт
нийцүүлсэн хууль тогтоомжийн бусад
актууд батлагдан үйлчилсний дүнд энэ
салбарын төрийн бодлого, эрх зүйн
зохицуулалтын механизм-хэв маяг нь
нийгмийн ухамсар, ахуйд тодорхой
хэмжээгээр төлөвшин бүрэлдсэн гэж
хэлж болно.

Гэвч дэлхий дахинд өрнөх болсон
глобалчлалын нөлөө, 1990-ээд оноос
манай оронд эрчээ авсан ардчилсан үйл
явц, нийгмийн бүх салбарыг шинэтгэх
улс төрийн бодлого, хүсэл эрмэлзлэл,
нийгмийн ахуй, ухамсарын өөрчлөлтүүд
нь хорих ял эдлүүлэх салбарын эрх
зүйн орчин, практикийг нэг талаас бид
бүхний сонгосон зах зээлийн нийгмийн
хуулиудтай, Үндсэн хуулийн эх орондоо
хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм

¹ Тухайлбал, халдашгүй чөлөөтэй байх, тайван
жагсаал, цуглаан хийх, нам, олон нийтийн бусад
байгууллага байгуулах, эвлэлдэн нэгдэх, чөлөөтэй
зорчих, оршин суух газраа сонгох, ажил мэргэжлээ
чөлөөтэй сонгох, шууд болон төлөөлөгчдийн
байгууллагаараа уламжлан төрийг удирдах
хэрэгт оролцох, сонгох, сонгогдох зэрэг)



ногцлуулан хөгжүүлэх эрхэм зорилготой уялдуулах, ногоо талаас олон улсын нийтлэг дэвшилтэт жишиг-стандартад хүргэн нийцүүлэх, гуравдагч талаасаа үндэсний онцлог, нийгэм-эдийн засгийн боломж нөхцөлдөө тулгуурлан өөрчилж шинэ шатанд гаргахыг улам бүр шаардах боллоо.

Хэдийгээр манай улс сүүлийн 30 гаруй жилийн хугацаанд энэ салбарт эрх зүй, практикийн чамлахааргүй ололт амжилтад хүрсэн боловч нийгмийн хөгжил дэвшил, төр засгийн бодлоготой уялдан цаашид ч өөрчлөлт-шинэтгэлийг хийх бодит хэрэгцээ шаардлага байна.

Иймээс эрхэлж буй ажил-албан тушаалын онцлог, энэ салбарын судалгааг эрхлэх хүсэл сонирхол дээрээ тулгуурлан илтгэлийн түвшинд шинээр боловсруулж буй төрөлжсөн хуулийн төсөлд дараах зохицуулалтад онцгойлон анхаарал хандуулахыг уриалж зарим нэг санаагаа /саналаа/ товчоор илэрхийлэхийг хүслээ. Үүнд:

1-рт: Үзэл баримтлал, зарчмын шинжтэй дараах зохицуулалт төрөлжсөн хуулийг боловсруулах, батлах, хэрэгжүүлэхэд шаардлагатай гэгж үзлэг. Энэ нь:

1.1. Монгол улсын эрх зүйн тогтолцооны тулгуур, хамгийн дээд хүчин чадалтай эх сурвалж болох Үндсэн хуулийн хорих ял эдлүүлэх ажиллагаанд хамаарч болох зарим хэм хэмжээг салбарын хуулийн түвшинд хэрхэн бататган хэрэгжүүлэх вэ гэдэг асуудал юуны өмнө үүнд хамаарна. Тухайлбал,

- "...Тороос бүх нийтийн ерөнхий боловсролыг толборгүй олгоно" /Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.7/

- "...хуулиар ногдуулсан албан татвар толох,...эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах...нь иргэний үндсэн үүрэг" /Үндсэн хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3, 17.1.4/

- "Хөдөлмөрлөх, ... , үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх нь ... иргэний журамт үүрэг мөн" /Үндсэн хуулийн 17 дугаар зүйлийн 17.2/ гэсэн заалт тус тус болно.

Энэ хүрээнд түүнчлэн Гэр бүлийн тухай хуулийн дараах зохицуулалтыг ч хамруулж болно. Энэ нь:

- "гэр бүлийн гишүүд² нь бие биеэ тэжээн тэтгэх үүрэгтэй" /хуулийн 10 дугаар зүйлийн 10.10.3/

- "эцэг, эх... хүүхдээ асран хамгаалах, тэжээн тэтгэх үүрэг хүлээнэ" /хуулийн 26 дугаар зүйлийн 26.2.2/

- "эцэг, эх нь насанд хүрээгүй болон насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдээ тэжээн тэтгэх үүрэгтэй" /хуулийн 38 дугаар зүйлийн 38.1/

- "хөдөлмөрийн чадвартай хүүхэд нь төрүүлсэн, үрчлэн авсан хөдөлмөрийн чадваргүй эцэг, эх, хойт эцэг, хойт эхээ тэжээн тэтгэх үүрэгтэй" /хуулийн 43.43.1/

² "Гэр бүлийн гишүүн гэж гэрлэгчид, тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд болон төрөл, садангийн хүнийг хэлнэ" /Гэр бүлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4/

"Төрлийн хүн гэж гэрлэгчийн эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, ач хүү, ач охин, зээ хүү, зээ охин, тэдгээрийн хүүхдийг хэлнэ" /хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5/

"Садангийн хүн гэж гэрлэгчийн төрсөн ах, эгч, дүү, авга, нагац, тэдгээрийн хүүхдийг хэлнэ" /хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6/

"Гэрлэлтээ бүртгүүлээгүй хүмүүсийн дундаас төрсөн хүүхэд нь гэрлэлтээ бүртгүүлсэн гэр бүлээс төрсөн хүүхдийн адил эрх эдэлж, үүрэг хүлээнэ" /хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5/



1.2. “Олон улсын байгууллагаас хорих ял эдлүүлэх болон хоригдол-ялтантай харьцах асуудлаар гаргасан зөвлөмжүүдийг³ хорих ял эдлүүлэх хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн журмын хүрээнд **нийгэм-эдийн засгийн бодит боломж, нөхцлөө харгалзан хэрэгжүүлнэ**” гэсэн зохицуулалтыг төрөлжсөн хуульд оруулах шаардлагатай.

1.3. “Хорих ял эдлүүлэх хууль **тогтоомж нь** хууль дээдлэх, хүнлэг, ардчилсан ёс, хуулийн өмнө хоригдлууд адил тэгш эрхтэй байх, ял эдлүүлэх ажиллагааг **ялгамжтай**⁴, хоригдол бүрийн онцлогт⁵ тулгуурлан зохион байгуулах, хоригдлыг нийгэмшүүлэх, албадлагын болон хүмүүжлийн арга хэмжээний үр нөлөөг эрхэмлэх, хоригдогсдын эерэг зан байдлыг хөхүүлэн дэмжиж-урамшуулах зарчмуудад тулгуурлана” гэж хуульчилж болох юм.

Тэгвэл өнөөгийн мөрдөж буй хуульд “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны эрх ашиг сонирхлыг хүндэтгэх, шуурхай, энэрэнгүй байх зарчимд үндэслэнэ⁶” хэмээн цөөн хэдэн үзэл санаагаар явцууруулан, онцлог байдлыг нь илэрхийлэлгүй ядмаг хуульчилсан гэж үздэг.

1.4. Зах зээлийн хууль, шударга ёс, хүнлэг энэрэнгүй байх зарчмын хүрээнд хоригдолд наад зах нь хоол хүнснийхээ зардлыг хариуцах үүргийг хүлээлгэх ёстой. Харин тахир дутуугийн

групптэй, өвчний учир эмчлүүлж буй хоригдол, жирэмсэн, нялх бага насны хүүхэдтэй эмэгтэй хоригдлууд хоол хүнсний төлбөрөөс чөлөөлөгдөх зохицуулалт байж болох юм.

Энд насанд хүрээгүй ял эдлэгсдийг хамруулаагүй ба гол үндэслэл-шалтгааныг судлаачийн зүгээс шинэчлэлийн Засгийн газраас боловсруулж УИХ-д өргөн мэдүүлсэн эрүүгийн шинэ хуулийн төслийн үзэл баримтлалтай⁷ холбосноор тайлбарлагдана.

Иймээс хорих байгууллагын төсөв нь улсын санхүүжилт болон хоригдлоос гаргуулах хоол хүнсний төлбөрөөс бүрдэх боломжтой.

Харин хуульд “Хорих байгууллагын төсөв нь түүний хуулиар хүлээсэн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэх нөхцлийг хангасан байвал зохино” гэж тусган бататгавал зохино.

Хорих байгууллагын төсвийг бүрдүүлэх энэ зохицуулалт хэрвээ дэмжигдэн хуульчлагдвал **хоригдлыг ажил хөдөлмөрөөр /ажлын байраар/ хангах явдал хорих байгууллагын нэг гол үүрэг нь болно.**

Иймээс түүнийг хэрэгжүүлэхэд нэг талаас хорих байгууллагын идэвхтэй, санаачлагатай үйл ажиллагаа чухал нөхцөл болохоос гадна хамгийн гол нь төрийн холбогдох байгууллагаас **хорих байгууллагын ажлын байр, орчин нөхцлийг бүрдүүлэх, үйлдвэрлэл эрхлэх явдлыг нь эрх зүйн зохицуулалтаар хангах үүргийг хуульчлах ёстой. Тухайлбал: хорих**

³ тунхаглалын заалтуудыг

⁴ Принцип дифференциации

⁵ Принцип индивидуализации

⁶ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 3 дугаар зүйл

⁷ Гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүмүүст хорихоос өөр төрлийн ял оногдуулах бодлого баримтална.



байгууллагад бүтээгдэхүүний захиалга огч худалдан авах, бүтээгдэхүүнийг нь ашигийн, худалдааны татвараас чөлөөлөх, үйлдвэрлэлийн техник хэрэгсэл, эд зүйлсийг нь гаалийн, газар, барилга байгууламжийг үл хөдлөх хоронгийн, орон нутгийн^{*} татвар хураамжаас чөлөөлөх нь нэн чухал.

2-рт: Төрөлжсөн хувулийн төсөлд дараах харилцааг бие даасан институт эсвэл хэм хэмжээний түвшинд нарийвчилан шинээр нэмж зохицуулах шаардлага бий. Энэ нь:

2.1. Хорих ял эдлэгсдийн тодорхой бүлгүүдийн асуудал. Үүнд:

а/ Хөгжлийн бэрхшээлтэй /хараагүй, дүлий, хэлгүй, гаргүй, хөлгүй суумгай, сэтгэцийн оорчлолт-оюун ухааны хомсдолтой зэрэг/, өвчтэй хоригдлуудын ахуйн хангалт, үйлчилгээ /тухайлбал: унтах ор, суух ширээ сандал, бие засах оргоо, зорчих тусгай зам, хэрэглэх хоол хүнс, унших ном зохиол гэх мэт/, түүнчлэн хөдөлмөр эрхлэлт, эрх ашгаа хамгаалах зэрэг бусад асуудал

б/ Эмэгтэй хоригдлын ял эдлэх нөхцөл журам, ахуй хангалт, эргэлт уулзалт, чөлөө гэх мэт бусад асуудал

в/ Гадаад улсын харъяалалтай хоригдогсдоос хорих байгууллагын захиргаа, алба хаагч, бусад хоригдолтой, шүүх, эрх мэдэл, хууль сахиулах байгууллагатай хэл ярианы бэрхшээл саадгүй ойлголцох, мэдээлэл авах, өгөх, мөн өөрийн /эсвэл хамаарах/ улсын дипломат төлөөлөгчийн газар, төлөөлөгчтэй холбоо тогтоон харьцах асуудал

^{*} Хэрэв цаашид энэ төрлийн татвар хураамж бий болвол.

г/ Зарим бүлгийн, тухайлбал, ял эдлэхээс өмнө шүүх эрх мэдэл, хууль сахиулах байгууллагад ажиллаж байсан, мөн зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн удирдагч- гишүүнийг бусад хоригдлоос тусгаарлан ял эдлүүлэх эрх зүйн зохицуулалт, практикийн асуудлыг үүнд юуны өмнө хамааруулж болно.

2.2. Хорих байгууллагад онцгой нөхцөл бий болсон үед тогтоох "Дэглэм"-ийн зохицуулалтыг дараах хэсэг, агуулгаар хуульчлах шаардлага байна. Энэ нь:

-1. "Байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон, хууль ёсны байгуулалд бодитой заналхийлэл бий болсны улмаас Үндсэн хуулийн дагуу хорих байгууллагын байрлаж буй нутаг дэвсгэр (засаг захиргааны нэгж, бүс) онц байдал, дайны байдлын журам-нөхцөлд шилжсэн, тэрчлэн хорих байгууллагад нийтийн эмх замбараагүй байдал үүсч хоригдлууд бүлэглэн байгууллагын захиргаанд захирагдахаа больсон үед эрх хэмжээнийхээ дотор ердийн арга хэрэгслээр тохиуулах боломжгүй бол салбарын төрийн захиргааны төв байгууллагын⁹ дарга Улсын Ерөнхий прокурортой зөвшилцөн тушаал гарган тухайн хорих байгууллагад "Онцгой нөхцлийн дэглэм"-ийг 30 хүртэл хоногийн хугацаагаар тогтоож болно.

Энэ тохиолдолд хоригдлын зарим эрхийг хязгаарлахын зэрэгцээ хамгаалалт-хяналтын хүч нэмэгдүүлсэн дэглэм тогтоож хорих байгууллага руу орох, гарах болон доторхи хөдөлгөөний тусгай журам үйлчилнэ. Мөн хорих ангийн дотоод цагийн

⁹ Магадгүй хойшид энэ субъект "Хорих Байгууллагын Удирдах Газар" гэж нэрлэгдэх боломжтой.



хуваарь, хөдөлмөр эрхлэлт, сургалт, соёл хүмүүжил, нийгэмшүүлэх арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөнд өөрчлөлт оруулна. Хэрэв “Онцгой нөхцлийн дэглэм” зарласан шалтгаан энэ хугацаанд арилаагүй бол дахин 30 хоногоор сунгаж болно.

-2. Хоригдлууд, алба хаагч, бусад хүмүүсийн амь нас, эрүүд мэндэд шууд ноцтой заналхийлэл үүссэн хойшлуулшгүй нөхцөлд **тухайн хорих байгууллагын дарга шийдвэр гарган** дээрхи арга хэмжээг авч болох ба энэ талаар нэн даруй эрх бүхий албан тушаалтанд илтгэнэ. Мэдээлэл хүлээн авснаас хойш энэхүү салбарын төрийн захиргааны төв байгууллагын дарга 3 хоногийн дотор “Онцгой нөхцөлийн дэглэм”-ийг батлан тушаал гаргах эсвэл хүчингүй болгоно гэсэн зохицуулалтыг хуульчлах шаардлагатай”.

3-рт: Салбарын хууль тогтоомжийн уламжлагдаж ирсэн зарим зохицуулалтыг өөрчлөх шаардлага бий. Үүнд:

3.1. Хоригдлын эргэлт уулзалтын эрх зүйн зохицуулалтын хувьд

а/ Гянданд ял эдлэж буй хоригдогсдол удаан хугацааны уулзалтавахэрхтэйбайхзохицуулалтыг хуульчлах.

б/ Хоригдол удаан хугацааны уулзалтыг түр хугацааны 3 хүртэл уулзалтаар, удаан, түр хугацааны уулзалтыг утсаар ярих эрхээр **солих боломжийг бий болгох**

Мөн утсаар ярих уулзалтыг орчин үеийн техник технологийн дэвшилд тулгуурлан online-аар холбогдон **бие**

биенээ харж ярих боломжтой байдлаар зохион байгуулах эрх зүйн орчинг бий болгох

в/ Удаан хугацааны уулзалтыг хорих байгууллагын байрлалд болон **түүний гадна орших зочид-дэн буудалд явуулахыг ч зөвшөөрч болох юм.**

Хэрвээ цаашид хоригдол өөрийн хоол хүнсний зардлыг хариуцах зохицуулалт хуульчлагдвал удаан хугацааны уулзалтын хугацаан дах зардлыг хасч тооцох эрх зүйн орчин байх нь дамжиггүй.

Энэ дашрамд нэг өрөөнд хоёр ба түүнээс дээш хоригдогсдын гэр бүл удаан хугацааны уулзалт нэгэн зэрэг зохион байгуулж буй өнөөгийн практикийг даруй халах шаардлагатай.

3.2. Хоригдлын захидал харилцааны зохицуулалтын хувьд

а/ Хоригдлоос захидал, цахилгаан мэдээ илгээхэд аливаа тоон хязгаарлалттогтоохшаардлагагүйгэж үзэж байна. Харин захидал, мэдээний агуулга, илэрхийллээс нь шалтгаалан хориг тавьж болно. Учир нь захидлаар харилцах нь хоригдлоос нийгмийн хэлхээ холбоогоо батжуулах болон бусад олон зүйлд, тухайлбал: санал бодлоо зөв илэрхийлэх, зөв, сайхан, гаргацтай бичих, эелдэг боловсон, урмын, сайшаалын үг хэлж сурах, сууж сурах болон зөв сэтгэлгээ төлөвших зэрэгт суралцахад ач холбогдолтой гэж үзэж байна.

Тэгвэл өнөөдөр мөрдөж буй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.2, 109 дүгээр зүйлийн 109.4 –д зааснаар онцгой

дэглэмд ял эдлэгсэд сард 2 удаа, гянданд ял эдлэгсэд сард 1 удаа захидал илгээж болох зохицуулалт үйлчилдэг.

б/ **Хоригдлоос хорих байгууллагыг** удирдах дээд шатны, мөн шүүх, прокурор, хүний эрхийн үндэсний комисс зэрэг хяналт, шалгалт хийх тусгайлсан чиг үүрэг бүхий бусад байгууллага, албан тушаалтанд хандсан **захидлыг тухайн байгууллагын зүгээс уншиж хянах эрхгүй** бөгөөд амралт, баярын өдрийг оролцуулалгүй 1 хоногоос хэтрүүлэлгүйгээр **баталгаат шуудангаар** илгээх зохицуулалтыг бий болгох шаардлагатай.

3.3. Хоригдлын чөлөөний тухайд

а/ Өнөөдөр зөвхөн жирийн дэглэмд хорих ял эдлэгсэд хуульд заасан нөхцөл бүрдсэнээр чөлөө авах боломжтой байна.

Энэ зохицуулалтыг дэглэмээр нь бус, субъектын хязгаарлалт тогтоох замаар шийдвэрлэх нь илүү ач холбогдолтой гэж үздэг.

Тодруулбал гянданд ял эдлэж байгаа болон бүх насаараа /эсвэл хугацаагүй/ хорих ялтай, мөн ДОХ, нийгмийн халдварт өвчтэй, согтуурах, мансуурах донтой бөгөөд холбогдох эмчилгээнд бүрэн хамрагдаагүй, тэрчлэн хорих ялын тодорхой хувийг эдлээгүй /үүнийг хуульд тодорхой заах/, сахилгын шийтгэлтэй хоригдлуудын чөлөө олгох явдалд хязгаарлалт тогтоож болох юм.

б/ Мөн **чөлөө олгох нөхцлийг өргөжүүлэх, хугацааг нэмэгдүүлэх** шаардлагатай. Өөрөөр хэлбэл "... **төрөл, садангийнх нь** хүн хүндээр өвчилсөн буюу нас барсан, байглийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсоны

улмаас ар гэрт нь үлэмж хор хөнөөл учирсан бол жирийн дэглэмтэй хорих ангийн ялтанд 7 хүртэл хоногийн чөлөө олгож болох¹⁰ **өнөөгийн зохицуулалт нь нэр томьёоны хувьд бусад төрөлжсөн хуультай зөрүүтэй болно.**

Учир нь Гэр бүлийн тухай хуулиар **төрөл, садан, гэр бүлийн гишүүн¹¹ гэсэн нэр томьёонууд** тус тусын агуулгатай.

Энэ хүрээнд хоригдолд олгох **чөлөөний хугацаанд /7 хүртэл хоногт/ очих, буцах зам хоногийг оролцуулахгүй байх** зохицуулалт хийх шаардлагатай. Учир нь алслагдсанаймагт (тухайлбал: Ховд, Увс, Баян-Өлгий, Завхан, Говь-Алтай) автомашинаар нэг талдаа 2 хүртэл хоног явдаг, мөн онгоц өдөр бүр нисдэггүй зэрэг өөрийн орны бодит амьдралыг бид харгалзах ёстой.

Хоригдолд чөлөө олгох нөхцлийг дараах тохиолдлуудад өргөжүүлэн зөвшөөрсөн бусад орны дэвшилтэт практикийг ч нутагшуулан хуульчилж, хэрэгжүүлж болох юм. Үүнд:

-1) Хорих ял эдлэх шүүхийн шийдвэр нь хүчин төгөлдөр болж зохих хорих байгууллагад хуваарилагдахын өмнө **насанд хүрээгүй хүүхэдтэй орх толгойлсон эх, ганц бие эмгийн хувьд тэднийгээ хаана байрлуулж, хэнээр асран халамжлуулах болон шаардлагатай гэж үзвэл орон байр, цэцэрлэг, сургууль, өвөлжилтийн бэлтгэлийг хангахад нь зориулж 7 хүртэл хоногийн чөлөө олгох**

-2) Хорих байгууллагаас суллагдахын өмнө хүсэлтийг нь үндэслэн ажлын байр, суурьшин амьдрах

¹⁰ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 107 дугаар зүйлийн 107.5 хэсэг

¹¹ эхнэр эсвэл нөхөр, тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд



орон гэрийн асуудлаа зохицуулахад нь хоригдолд мөн хугацааны чөлөө /орон нутгийн/ олгох

-3) Жилийн турш ажилласан хоригдолд **хөдөлмөрийн хуулийн дагуу 14 хоногийн цалинтай амралт олгох**, мөн тодорхой хоногийг нь **ар гэртээ харих чөлөөгөөр** эдлэх боломжийг ч үүнд хамруулах хэрэгтэй.

3.4. Хоригдлоос биедээ бэлэн мөнгө хадгалах өнөөгийн эрх зүйн зохицуулалтын орчинг хязгаарлах шаардлага байна. Учир нь энэ зохицуулалтыг бий болгосон нийгмийн зарим шалтгаан, нөхцөл өнөө цагт үгүй болсон.

3.5. Хорих байгууллагын, хоригдлын аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалах нийтлэг шаардлагын ши үндэс болгон эргэлт, уулзалтын хүнс, бусад эд зүйлсийг зөвхөн тухайн хорих ангийн дэлгүүрээс, ресторан-гуанз-кафегаас худалдан авч үйлчлүүлэх, хэрэгтэх ажрамд шилжисж болох юм.

Учир нь хорих байгууллагад эргэлт уулзалтаар нэвтрүүлж буй хүнсний бүтээгдэхүүн, эд юмсад хориглосон зүйлс орж байгаа эсэхийг бүрэн хянах **техник хэрэгслийн, хүний нөөцийн, алба хаагчийн мэдлэг, ур чадварын** боломж нөхцөл хязгаарлагдмал ба шийдвэрлэхэд ихээхэн хүндрэлтэй.

Иймээс энэ зохицуулалт, бусад хүчин зүйлтэй уялдан удирдлагын зүгээс алба хаагчдыг хардан сэжиглэх практик их байдаг ба энэ нь ч байгууллага, хамт олны дунд таагүй уур амьсгал бий болгодгыг хүлээн зөвшөөрөх ёстой.

Ингээд илтгэлд тавигддаг

багтаамжийн шаардлагыг харгалзан саналаа хязгаарлаж цаашдын илтгэл-нийтлэлээрээ та бүхэнд бусад санал бодлоо хүргэхийг эрмэлзэе.

Гэхдээ саналууд маань бусад оронд үр ашгаа өгч буй дэвшилтэт зохицуулалт, бодит практик, мөн судлаачийн хувийн үзэл бодол тул авах гээхийн ухаанаар хандан ойлгоно гэдэгт бат итгэлтэй байна.